

Батлав. БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга

А.ЭНХБАТ

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн

“Витафит милк” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

С.БОЛОРСАЙХАН

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРОО

**“ВИТАФИТ МИЛК” ХХК “СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭР”-ИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Регистрийн дугаар: 5451469

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн:

П.Шинэцэцэг

НБОГ-ын ХБОБНХ-ын мэргэжилтэн:

Ж.Батзолбоо

Боловсруулсан:

“Витафит милк” ХХК-ны Чанарын инженер

Г.Банзрагч

Хянасан:

“Витафит милк” ХХК-ны Чанарын хяналтын

албаны дарга:

Х.Оюун-Эрдэнэ

2022 он

АГУУЛГА

Агуулга	2
Зургийн жагсаалт	3
Хүснэгтийн жагсаалт.....	4
Товчилсон үгсийн тайлбар.....	4
Төслийн товч танилцуулга.....	5
1.1 Төслийн зорилго	5
1.2 Төслийн байршил.....	6
1.3 Төслийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6
1.4 Төслийн түүхий эд, туслах материал.....	9
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	11
2.1 Үйлдвэрийн орчны дэд бүтцийн байдал	11
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	12
4. Байгаль орчны менежментийн тухайн ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	13
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	15
6. ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
7. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ	21
8. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ.....	23
9. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	24
10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ.....	26

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Үйлдвэрийн байршлыг сансрын зурагт буулган үзүүлэв (М 1:10000).....	6
Зураг 2. Үйлдвэрлэлийн дамжлага.....	6
Зураг 3. Үйлдвэрээс гарах бүтээгдэхүүн.....	7
Зураг 4. Сүүний үйлдвэр.....	7
Зураг 5. Үйлдвэрийн байрны агааржуулалтын систем, хоолой нь нэгдсэн, эргэлтийн систем бүхий автомат төхөөрөмж.....	7
Зураг 6. Түүхий эдийн агуулах.....	9
Зураг 7. Туслах материалын агуулах.....	10
Зураг 8. Бэлэн бүтээгдэхүүний агуулах.....	10
Зураг 9. Үйлдвэрийн шугам хоолой, систем угаасан хаягдал усны гаралтын хэсэг.....	12
Зураг 10. Систем угаасан ус болон үйлвэрийн байрны цэвэрлэгээнээс гарах хаягдал ус зайлуулах хоолой.....	12
Зураг 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	25

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Бэлэн бүтээгдэхүүний жагсаалт.....	8
Хүснэгт 2 Техник технологийн ус хэрэглээний тооцоо.....	11
Хүснэгт 3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал (жилээр).....	25
Хүснэгт 4. Нэмэлт ажлууд.....	26
Хүснэгт 5. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа.....	27

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОННУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
УСУГ	Ус сувгийн удирдах газар
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуй
БОХТ	Байгаль орчны хамгаалах төлөвлөгөө
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
СХЗГ	Стандарт хэмжил зүйн газар
ОХШХ	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр
НБХХ	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Витафит милк” ХХК нь Витафит группын охин компани бөгөөд 2016 оноос хойш сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа чиглэлээр тогтвортой үйл ажиллагаагаа явуулж байна. 2011 оноос ISO 9001:2008 (MNS ISO 9001:2010) стандартын шаардлагад нийцүүлэн чанарын удирдлагын тогтолцоог бий болгон, баримтлан хэрэгжүүлж, түүний үр нөлөөг байнга сайжруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байгаа ба 2016 онд ISO 22000:2005 Олон улсын хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. Бид бүтээгдэхүүнээ ариун цэврийн шаардлага бүрэн хангасан орчинд олон улсын стандартад нийцсэн, хамгийн сүүлийн үеийн технологи ашиглан өндөр хэмд ариутган, вакуум орчинд хаягдалгүй ажиллах технологи бүхий автомат савлагчаар бүтээгдэхүүнээ савлан дотоодын зах зээлд нийлүүлэн хэрэглэгчийн шаардлага, хэрэгцээг ханган ажиллаж байна.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан байгаль орчны асуудлуудтай холбоотой болзошгүй болон сөрөг нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, түүний сөрөг үр дагавар, түүнээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөөд байна.

Тус компани нь үйл ажиллагаа явуулж буй орчинд байгаль орчны зохистой менежментийг бий болгох зорилгоор байгаль орчныг хамгаалах арга хэмжээг жил бүр төлөвлөн хэрэгжүүлж байна.

Витафит милк ХХК-ийн мэдээлэл:

Төслийг хэрэгжүүлэгч ААН	ААН-ын улсын бүртгэлийн дугаар	РД	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг, байршил	Утас	Цахим шуудан
Витафит милк ХХК	9011277021	5451469	Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа	Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3-р хороо, Үйлдвэрийн гудамж-1, “Витафит” группын байр	345160, 343434, 345161, Факс: 344107	info@vitafit.mn n web: www.vitafit.mn

“Витафит милк” ХХК-ийн холбогдох албан тушаалтнуудын мэдээлэл

№	Нэр	Албан тушаал
1	С.Болорсайхан	Витафит милк ХХК-ийн Гүйцэтгэх захирал
2	Х.Оюун-Эрдэнэ	Витафит милк ХХК-ийн Чанарын хяналтын албаны дарга


1.1 Төслийн зорилго

Хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан сүү, сүүн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн дотоодын зах зээлд нийлүүлэх, монгол бүтээгдэхүүнийг дэлхийд таниулах.

1.2 Төслийн байршил

“Витафит милк” ХХК-ийн “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр” нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэр, Говийн замын урд талд, “Витафит” групп, “Номун Интертрейд” ХХК-ийн 7333,79м² талбай бүхий үйлдвэрийн байрыг түрээслэн үйл ажиллагаа явуулдаг.

Зураг



1. Үйлдвэрийн байршлыг сансарын зурагт буулган үзүүлэв (М 1:10000)

1.3 Төслийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Хүчин чадал: “Витафит милк” ХХК-ийн сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр нь жилд нийт 100 сая гаруй ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай ба үйлдвэрлэлийн үндсэн дамжлага цехүүд (сүү, тараг, аарц, цөцгий, зайрмаг, сырок, шүүс), түүхий эд, туслах материал, бүтээгдэхүүний агуулах зэргээс бүрдэнэ. Үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмжүүд нь технологи урсгалын дагуу угсрагдсан дамжлага хэлбэрээр ажиллах бөгөөд бүрэн автоматжсан үйлдвэр юм.

Техник, тоног төхөөрөмж: “Витафит милк” ХХК-ийн сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр 2016-2017 онд шинэчлэл хийж, олон төрлийн тоног төхөөрөмжийг шинээр суурилуулсан ба бүтээгдэхүүнийнхээ нэр төрлийг нэмэгдүүлэн Герман, Франц, Хятад, Япон, Швед, Финланд, Унгар улсын автомат техник, тоног төхөөрөмж ашиглан нарийн технологийн дагуу үйлдвэрлэж байна.




Зураг 2. Үйлдвэрийн дамжлага



Зураг 2. Үйлдвэрээс гарах эцсийн бүтээгдэхүүн



Зураг 4. Сүүний үйлдвэр



Зураг 5. Үйлдвэрүүдийн байрны агааржуулалтын систем, хоолой нь нэгдсэн, эргэлтийн систем бүхий автомат төхөөрөмж

Үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл: “Витафит милк” ХХК-ийн Сүүний үйлдвэр нь 30 нэр төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүн, 3 төрлийн шүүс, 22 нэр төрлийн зайрмаг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлдэг байна. Үйлдвэрийн бүтээгдэхүүний жагсаалтийг дор дэлгэрэнгүй оруулав.

Хүснэгт 3 Бэлэн бүтээгдэхүүний жагсаалт

№	Бренд	Бүтээгдэхүүний ангилал	Савалгаа	Бүтээгдэхүүний нэр төрөл
1	Өглөө	Ундны сүү	1000мл	Сүү 3.2%
2		Ундны сүү	500мл	Сүү 3.2%
3	Пороро	Ундны сүү	200мл	Ванильтай сүү
4		Ундны сүү	200мл	Гүзээлзгэнэтэй сүү
5		Ундны сүү	200мл	Шоколадтай сүү
6	Гоё	Ундны сүү	200мл	Шоколадтай сүү
7		Ундны сүү	200мл	Гүзээлзгэнэтэй сүү
8		Ундны сүү	200мл	Гадилтай
9	Өлзий	Ундны сүү	1000мл	Сүү 3.2%
10		Ундны сүү	500мл	Сүү 3.2%
11	Гэр	Ундны сүү	950мл	Гэр сүү
12	Өлзий	Йогурт	450г	Хар чавгатай йогурт
13		Йогурт	450г	Гүзээлзгэнэ йогурт
14		Йогурт	450г	Манго йогурт
15		Йогурт	450г	Ойн жимс йогурт
16		Йогурт	450г	Тоор, чангаанз йогурт
17		Йогурт	150г	Тасалгаат йогурт (Шоколадан бөмбөлөг)
18		Йогурт	150г	Тасалгаат йогурт (Мюсли)
19		Йогурт	180г	Үелсэн йогурт (Гүзээлзгэнэ)
20		Йогурт	180г	Үелсэн йогурт (Нэрс)
21		ГОЁ	Тараг	1000г
22	Йогурт		130г	Самар жимстэй йогурт
23	БАЛКАН	Йогурт	180г	Йогурт (ариутгасан)
24		Йогурт	950г	Йогурт (ариутгасан)
25	ГЭР	Йогурт	900г	Хар чавга (элекстер)
26		Йогурт	900г	Интоор (элекстер)
27		Йогурт	900г	Нэрс (элекстер)
28	Vitafit	Исэг цагаан идээ	170г	Пробиотик ундаа
29		Уураглаг цагаан идээ	200г	Уудаг аарц
30		Уураглаг цагаан идээ	950г	Уудаг аарц
31		Шар сүүний ундаа	200мл	Ундаа
32		Шар сүүний ундаа	950мл	Ундаа
33	Өлзий	Тослог цагаан идээ	300г	Зөөхий-20%
34		Тослог цагаан идээ	150г	Шар тос
35		Цөцгийн тос	200г	Цөцгийн тос-82.5%
36	АЛТАЙ	Цөцгийн тос	200г	Цөцгийн тос-75%
37	КАFFA	Кофе	200г	Латте кофе
38	ГЭР	Уураглаг цагаан идээ	450г	Ааруул
39	ПОРОРО	Уураглаг цагаан идээ	30г	Сырок (сүүн шоколадтай)
40		Уураглаг цагаан идээ	30г	Сырок (Ванильтай)

41		Уураглаг цагаан идээ	30г	Сырок (Иристэй)
42		Уураглаг цагаан идээ	30г	Сырок (Гүзээлзгэнэтэй)
43		Уураглаг цагаан идээ	30г	Сырок (Шоколадтай)
44		Зайрмаг	75г	Цөцгий чацарганатай сүүн зайрмаг
45		Зайрмаг	75г	Цөцгий, ирисний чөмөгтэй сүүн зайрмаг
46		Зайрмаг	65г	Аарцтай сүүн зайрмаг
47		Зайрмаг	65г	Аарц, чацарганатай сүүн зайрмаг
48		Зайрмаг	65г	Гүзээлзгэнэ, Киви, Гадил жимстэй сүүн зайрмаг
49		Зайрмаг	65г	Гүзээлзгэнэ, Ханборгоцой жимстэй сүүн зайрмаг
50		Зайрмаг	65г	Алим, интоор жимстэй сүүн зайрмаг
51		Зайрмаг	65г	Манго жимстэй сүүн зайрмаг
52	ЦАС	Зайрмаг	75г	Цөцгийтэй
53		Зайрмаг	75г	Шоколадтай цөцгийтэй
54	СОНГОДОГ	Зайрмаг	75г	Цөцгийтэй пломбир
55		Зайрмаг	75г	Өтгөрүүлсэн сүүтэй цөцгийтэй зайрмаг
56		Зайрмаг	75г	Шоколадтай цөцгийтэй зайрмаг
57		Зайрмаг	65г	Бүрхүүлтэй цөцгийтэй пломбир
58		Зайрмаг	65г	Бүрхүүлтэй шоколадтай цөцгийтэй пломбир
59		Зайрмаг	65г	Бөөрөлзгөнөтэй пломбир
60		Зайрмаг	65г	Иристэй пломбир
61		Зайрмаг	65г	Шоколадтай самартай пломбир
62		Зайрмаг	65г	Матча цөцгийтэй зайрмаг
63	ГРАЦИЯ	Зайрмаг	65г	Бүрхүүлтэй, тирамису амттай шоколадтай пломбир
64		Зайрмаг	50г	Фисташка амттай цөцгийтэй зайрмаг
65		Зайрмаг	50г	Гүзээлзгэний амттай цөцгийтэй зайрмаг
66	ПОРОРО	Шүүс агуулсан ундаа	200мл	Лийр 10%
67			200мл	Цагаан усан үзэм 10%
68			200мл	Улаан усан үзэм 10%
69			950мл	Лийр 10%
70			950мл	Цагаан усан үзэм 10%
71			950мл	Улаан усан үзэм 10%

1.4 Төслийн түүхий эд, туслах материал

Түүхий эд: Үйлдвэрийн гол түүхий эд болон төрөл бүрийн жимсний өтгөрүүлсэн шүүс, зөөлөн эд, жимс зэргийг гадаад болон дотоодын зах зээлээс худалдан авч байна.



Зураг 6. Түүхий эдийн агуулах

Туслах материал: “Витафит милк” ХХК-ийн сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, цех дамжлагуудад дараах туслах материалуудыг дотоод болон гадаадын зах зээлээс худалдан авч ашиглаж байна. Үүнд:

- | | |
|--------------------------------|---------------------------------|
| - Химийн бодис, материал | - Скоч |
| - Рулон | - Цавуу (бөглөөний) |
| - Суурь хайрцаг | - Цавуу (суурь хайрцагны) |
| - Бөглөө (Цагаан) | - Кодны хуруу хор /0.2г/ Domina |
| - Бөглөө (Gold) | - Код шингэлэгч MC270 |
| - Өлзий сүүний бөглөө (цагаан) | - Кодны хор /кодны машины/ |
| - PPP тууз ТВА-21 | - Код цэвэрлэгч WL200 |
| - PPP тууз ТВА-3 | - Полиэтилен нимгэн хальс |



Зураг 7. Туслах материалын агуулах

Жижиглэн савласан сүү, сүүн бүтээгдэхүүнийг зориулалтын хуванцар авдар, эсвэл полиэтилен баглаагаар багцлан тээвэрлэлт, худалдаанд гаргана. Үйлдвэр болон Чанарын хяналтын алба хамтран бүтээгдэхүүний талаарх доор дурьдсан мэдээллүүдийг хаягжилтын дагуу хийж заавал дагалдуулна. Үүнд:

- Үйлдвэр, компанийн нэр
- Үйлдвэрлэсэн он, сар, өдөр
- Бүтээгдэхүүний нэр
- Шинжилгээний дүн
- Хадгалах хугацаа, нөхцөл
- Баталгаажуулсан ажилтны нэр, гарын үсэг зэрэг орно.

Хадгалах, тээвэрлэх: Сүү, сүүн бүтээгдэхүүн нь савлагааны материалын шинж чанар, технологийн процессоос шалтгаалан өөр өөр нөхцөлд хадгалдаг ба ерөнхий шаардлага болох нарны гэрлийн шууд тусгалгүй +0°C-аас +20°C-аас дээшгүй хэмд, агаарын харьцангуй чийгшил 75%-иас багагүй стандартад нийцсэн хөргөлттэй, эрүүл ахуйн шаардлага агуулахад хадгалж, зориулалтын хөргөлттэй (4±2)°C тээврийн хэрэгслээр тээвэрлэж түгээнэ.



Зураг 8. Бэлэн бүтээгдэхүүний агуулах

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Үйлдвэрийн орчны дэд бүтцийн байдал

Зам харилцаа: “Витафит милк” ХХК-ий үйлдвэрүүд нь “Говийн зам” нэртэй хатуу хучилттай авто замын урд талд засмал замаас ойролцоогоор 200-300м-ын зайд байрлана.

Цахилгаан хангамж: Цахилгаан түгээх сүлжээний нэгдсэн системд холбогдсон.

Ус хэрэглээ: “Витафит милк” ХХК-ийн үйлдвэр нь Улаанбаатар хотын цахилгаан эрчим хүч, зам тээвэр, харилцаа холбооны сүлжээний төвлөрсөн хотын үйлдвэрийн бүсэд байрлана. Тус үйлдвэр нь цэвэр болон бохир усны төвийн сүлжээнд холбогдсон ба техник технологийн хэрэгцээ, ажилчдын унд ахуй, үйлдвэрийн байр, өрөө тасалгааны цэвэрлэгээнд цэвэр ус авч ашиглана. Ус хэрэглээний төлбөр нь тоолуураар төлөгддөг.

Тус үйлдвэр нь бүтээгдэхүүнүүдээ үйлдвэрлэн гаргах техник, тоног төхөөрөмжүүдийн техникийн болон технологийн ус хэрэглээг дараах хүснэгтэд үзүүлэв. Технологийн цэвэрлэгээг өдөр бүр СІР буюу 5 шатлалт цэвэрлэгээг хийдэг.

Хүснэгт 4 Техник технологийн ус хэрэглээний тооцоо

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк дугаар	Хүчин чадал	Ажиллах цаг, жилд	Техникийн усны хэрэглээ, м ³ /жил	Технологийн усны хэрэглээ, м ³ /жил
1	Shikoku - Пюрпак савлах машин	SKS-SE30NH2S	3000ш/ц	1200	250.0	1200.0
2	Элекстер - савлах машин	FP2500	2500ш/ц	120	хэрэглээ байхгүй	400.0
3	GEA-боловсруулах төхөөрөмж	Pastuer	5000-10000л/ц	2143	24.0	8400.0
4	Хуурай сүү	BBU, VRC	2500л/ц	1100	2.0	10500.0
5	Сырокны шугам	BH5	5000ш/ц	2000	0.6	хэрэглээ байхгүй
6	Найрлага бэлтгэх танк	RBWG-01	20тн	250	хэрэглээ байхгүй	6500.0
7	Түүхий сүү хадгалах танк	BY10TTPG-03	20тн	300	хэрэглээ байхгүй	6500
8	Ариутгасан сүү хадгалах танк	BY10TBSNCG-03	20тн	300	хэрэглээ байхгүй	6500
9	Аарц бэлтгэх төхөөрөмж	GS-7	7000л	150	1.2	3200
10	Цөцгий боловсруулах төхөөрөмж	PG-05	500л/ц	500	1.0	2600

Тус компанийн ажилчдын унд ахуйн хэрэгцээнд болон ажлын байрны цэвэрлэгээ, ногоон байгууламжийг арчлах ажилд ус ашиглана. Ахуйн хэрэгцээнээс гарсан бохир усыг төв цэвэрлэх байгууламжийн шугам хоолойд нийлүүлнэ. Тус компани нь УСУГ-тай цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээ жил бүр хийгддэг.



Зураг 9. Үйлдвэрийн шугам хоолой, систем угаасан хаягдал усны гаралтын хэсэг



Зураг 10. Систем угаасан ус болон үйлвэрийн байрны цэвэрлэгээнээс гарах хаягдал ус зайлуулах хоолой

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болох газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, агаар, усан орчинд болзошгүй сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Тухайлбал:

- Хөрсний элэгдэл, эвдрэл
- Хөрсөн бүрхэвч бохирдол, доройтол
- Ус ашиглалт
- Эдэлбэр (газрын гадарга) газрын доройтох
- Агаарын чанарын өөрчлөлт (тээвэрлэлтийн үед орчны агаарт тоосжилт, агаарт түгээмэл тархацтай бохирдуулагч бодис CO, NO₂, SO₂ ялгарах)
- Ургамлан нөмрөг талхлагдах
- Физик бохирдол (дуу чимээ, шуугиан) зэрэгт болзошгүй сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Мөн хүний буруутай үйл ажиллагаа, осол, аюулт үзэгдлээс болзошгүй сөрөг нөлөөлөл үзүүлж болно. Тухайлбал:

- Байгаль цаг уурын өөрчлөлт (байгалийн аюулт үзэгдэл)
- Галын аюулгүй байдал алдагдах
- Химийн бодисын хэрэглээ
- Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймаг, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор, тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй.

Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдалд:

- Ажилгүйдлийн тоо буурах
- Амьжиргааны түвшин дээшлэх
- Өрхийн орлого нэмэгдэх

- Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
- Татварын орлого нэмэгдэх
- Орчны дэд бүтцийн байдал сайжрах
- Татварын орлогоор дамжин улсын төсөв хуримтлагдах мөнгөн дүн нэмэгдэх

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчныг хамгаалах хууль эрх зүйн орчин шинэчлэгдсэнтэй холбоотойгоор “Баруун Хуасай” ХХК нь “Витафит милк” ХХК-ийн “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр” төслийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг Монгол улсын БОНХСайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль Орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 тушаал, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2022 онд бүрэн шинэчлэн боловсруулсан.

Төслийн үйл ажиллагааны онцлог, байршил зэргээс шалтгаалан БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

4.1 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь төсөл хэрэгжүүлэгч “Витафит милк” ХХК-ийн “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр” төслийн албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартыг нэгтгэн тусгасан. Төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүр хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Ингэхдээ үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгох хэрэгтэй. Төслийн болон түүний нөлөөллийн бүс дэх бүх сөрөг өөрчлөлтөд мониторинг хийж, үнэлгээ хийх шаардлагатай. Энэ төлөвлөгөө нь төсөл хэрэгжүүлэгч жил бүр байгаль орчин хамгаалах төлөвлөгөө боловсруулахад ашиглагдах юм.

- MNS 2305-1994 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам
- MNS 3298-1990 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд
- MNS 3473-1983 Газар, газар эдэлбэр, газар ашиглалт, нэр томъёо, тэмдэглэл
- MNS 3985-1987 Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл
- MNS 5850-2008 - Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ
- MNS ISO 11074-1-2001 Хөрсний чанар. Хөрс хамгаалах бохирдлоос сэргийлэхтэй холбогдох нэр томъёо, тодорхойлолт. тайлбар толь 1-р хэсэг
- MNS 6147-2010 Байгаль орчны бохирдол, бохирдлын хяналт ба хамгаалалт -Агаар, хөрсөн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- MNS ISO 5667-1 : 2002 Усны чанар. Дээж авах 1-р хэсэг. Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар

- MNS ISO 5667-6-2001 Усны чанар. Дээж авах 6-р хэсэг. Гол горхины уснаас дээж авах заавар
- MNS ISO 5667-4-2001 Усны чанар. Дээж авах 4-р хэсэг. Байгалийн ба хиймэл нуураас усны дээж авах заавар
- MNS ISO 5667-3:1999 Усны чанар. Дээж авах 3-р хэсэг. Дээжийг боловсруулах ба хадгалах зөвлөмж
- MNS 4586-1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
- MNS 4047-1988 Усан Орчин. Гадаргын усны чанарыг хянах журам
- MNS 5918-2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага
- MNS 4118-1991.Ойн нэр томьёо, тодорхойлолт
- MNS 6191-2010. Ховор ургамал тарималжуулах ерөнхий шаардлага
- MNS 3474:2003 Ургамал хамгаалал. Нэр томьёо, тодорхойлолт
- MNS 3475:2003 Ургамлын хорио цээр. Нэр томьёо, тодорхойлолт
- Зэрлэг амьтныг хамгаалах тухай
- MNS ISO 14064-1-2011 - Хүлэмжийн хий. Байгууллагад хүлэмжийн хийн ялгаралт ба шингээлтийг тооцоолох
- MNS 4219:1994 - Байгаль орчныг хамгааллын стандартын систем. Аж ахуйн нэгжийн экологийн паспорт. Үндсэн дүрэм
- MNS ISO 14004:1996 - Байгаль орчны менежментийн тогтолцоо. Зарчим, тогтолцоо, бүрдүүлэлтийн ерөнхий аргачлал
- MNS ISO 14011:1996 - Байгаль орчны аудитын гарын авлага. Аудитын үйл ажиллагаа. Байгаль орчны удирдлагын тогтолцооны аудит
- MNS ISO 14001:1998 -Хүрээлэн байгаа орчны удирдлага-Байгаль орчны менежментийн тогтолцоо
- MNS ISO 14050:1998 - Хүрээлэн байгаа орчны удирдлага-Тайлбар толь

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

5.1 Агаар орчныг хамгаалах арга хэмжээ

Гол ба болзошгүй нөлөөлөл	№	Урьдчилан сэргийлэх болон бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Орчны агаарын чанарын өөрчлөлт	1	Бохирдлын ялгаруулалт бага, ашигт үйлийн коэффициент өндөртэй технологи сонгохдоо мэргэжлийн зөвлөгөө авах	Агуулахад	Зөвлөгөө	Дотоод зардал	Жилд 1 удаа	MNS 4598:2011
	2	Орчны сул хөрс, агаар орчин бохирдуулах эх үүсвэрийг багасгах	Үйлдвэрийн хэмжээнд	Зураглал	Дотоод зардал	Жилд 1 удаа	
	3	Ногоон байгууламжийн арчилгаа, тордлогыг сайжруулах, хэмжээг нэмэгдүүлэх	Төслийн нийт талбайд	Зураглал	Дотоод зардал	Тогтмол	MNS 5918-2008
Агуулах, хими-биологийн лабораторид агаарын чанар муудаж хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	4	Ажлын байр, агуулах, лаборатори зэрэг шаардлагатай газруудад тоос цэвэрлэх, агааржуулах систем, сэнс суурилуулах	Агуулах, лаборатори, дотоод цехийн шаардлагатай хэсгүүдэд	Зураглал	1,500.0	Тухай бүр	MNS 6063:2010
Бодис уурших, исэлдэн-ангирхах урвалд орох, салхины нөлөөгөөр тархах зэргээр агаарын чанарыг өөрчлөх	5	Газар хөдлөл, хүчтэй салхи шуурга, аянга цахилгаан, үерийн аюулд химийн бодисын агуулах болон үйлдвэрийн үндсэн барилга байгууламжийн бэлэн байдлыг хянан баталгаажуулах	Төслийн нийт талбайн хэмжээнд	Нэгж тайлан	Дотоод зардал	Жилд 1 удаа	Үйлдвэрийн барилга, цэцэг байгууламжийн инженерийн төлөвлөлт болзошгүй эрсдэлд бэлэн эсэхийг тодорхойлно.
	6	Химийн бодисыг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэрээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй нөхцөлд хадгалах	Төслийн нийт талбайн хэмжээнд	Нэгж тайлан	Дотоод зардал	Тогтмол	MNS 6458:2014
Болзошгүй аюул, ослын үед хорт хий ялгарч, агаарын чанарт нөлөөлөх	7	Химийн бодисын агуулах болон үйлдвэрийн үндсэн барилга байгууламжийг MNS 6458-2014 стандартад нийцүүлэх	Төслийн нийт талбайн хэмжээнд	Нэгж тайлан	2,000.0	Тогтмол	MNS 6458:2018
	8	Химийн бодис холих, уусгах үйлдлийг битүү саванд буюу хий тархахаас хамгаалсан нөхцөлд хийх	Агуулах, цехүүд	ХАБЭА бүртгэл	Дотоод зардал	Тогтмол	MNS 6418:2018
	9	Химийн бодисын хаягдал үлдэгдлийг аюултай хог хаягдал материал устгахад мэргэшсэн мэргэжлийн байгууллагаар устгуулах	Төслийн нийт талбайн хэмжээнд	Нэгж тайлан	Дотоод зардал	Тогтмол	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
	10	Химийн бодисын хаягдал үлдэгдлийг орон нутгийн мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл дүгнэлтийн дагуу устгах	Төслийн нийт талбайн хэмжээнд	Нэгж тайлан	Дотоод зардал	Тогтмол	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль

	11	Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслүүдэд учирсан гэмтлийг тухай бүр янзалж, дотоод шаталтын хөдөлгүүрийг засварлаж, шинэчлэх	Төслийн нийт талбайн хэмжээнд	Нэгж тайлан	Дотоод зардал	Тогтмол	
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотой үүсэх хорт хийн нөлөөлөл	12	Хөрсөн бүрхэвчийн элэгдэл, эвдрэлийг багасгах, агаар дахь тоосонцорын хэмжээг бууруулах зорилгоор ногоон байгууламж байгуулсан байна.	Төслийн нийт талбайн хэмжээнд	Нэгж тайлан	Дотоод зардал	Жил бүр	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
	13	Хуурай болон салхины хурд ихтэй үед автозам, талбайг услах		Зөвлөгөө	Дотоод зардал	Тухай бүр	MNS 4585:2016
	14	Автотээврийн болон хүнд машин механизмын хөдөлгүүрийн сул ажиллагааг хязгаарлах		Зөвлөгөө	Дотоод зардал	Тухай бүр	MNS 4585:2016
	15	Хөдөлгүүрт техник тоног төхөөрөмжид тогтсон хуваарийн дагуу засвар үйлчилгээг хийх замаар яндангийн утааг багасгах		Нэгж тайлан	Дотоод зардал	Тогтмол	MNS 4585:2016
Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь салхины хурд, агаарын чийгшил болон хуурайшилт зэргээс жилийн дөрвөн улиралд харилцан адилгүй байдаг	16	Агаарын чанар, дуу шуугианы хяналт шинжилгээг тогтмол хийх	Төслийн нийт талбайн хэмжээнд	Нэгж тайлан	ОХШТ-г зардлыг тусгав.	Тогтмол	MNS 4585:2016
	17	Агуулахад агаарын чанарын хэмжилт хийж байх ба хэрэв зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрвэл тэр даруй хяналтын арга хэмжээ авах	Төслийн нийт талбайн хэмжээнд	Нэгж тайлан	Дотоод зардал	Урирал тугамд	MNS 4585:2016

5.2 Газрын гадарга, хөрсөн орчныг хамгаалах арга хэмжээ

Гол ба болзошгүй нөлөөлөл	№	Урьдчилан сэргийлэх болон бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Химийн бодис тээвэрлэх, түгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаа шаардлагын дагуу зөв явагдаагүйгээс химийн бодис хөрсөнд алдагдаж, хөрс бохирдуулах	1	Химийн бодис тээвэрлэх тээврийн хэрэгслийг тогтоосон маршрутаар явуулах	Төслийн нийт талбайн хэмжээнд	Маршрут	Дотоод зардал	Тухай бүр	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам /Эрүүл мэндийн сайдын 54А/
	2	Химийн бодистой холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа агуулах, газруудын шалыг химийн үйлчлэлд гэсвэртэй зузаан материалаар хийх. Тос тослох материал болон химийн бодис хадгалж байгаа болон ашиглаж буй газар үерийн хамгаалалт, даланг инженерчлэлийн нарийвчилсан үндэслэл тооцоотой хийж өгөх	Агуулахад	Нэгж тайлан	2,000.0	Тухай бүр	MNS 6458:2014
	3	Хөрс, болон усан орчинд химийн бодис алдагдсан тохиолдолд тухайн бодисыг цаашид тархахаас сэргийлж, шуурхай шингээж авах	Төслийн нийт талбайн хэмжээнд	Нэгж тайлан	Дотоод зардал	Ослын үед	MNS 6458:2014

Сүү, суун бүтээгдэхүүний үйлдвэрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023

Агуулах орчмын хөрс технологийн болон ахуйн хог хаягдлын улмаас бохирдох	4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг жил бүр боловсруулан хэрэгжүүлнэ. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажиллах, хог хаягдлын улмаас хөрсөн орчин бохирдохгүй байх арга хэмжээг авч ажиллана.	Төслийн нийт талбайн хэмжээнд	Нэгж тайлан	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль
	5	Агуулахын дотор болон гадна талбайн хөрсний элэгдэл, эвдрэлээс урьдчилан сэргийлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Төслийн нийт талбайн хэмжээнд	Зураглал	Дотоод зардал	Тогтмол	MNS 6458:2014
	6	Сул шороотой хэсгүүдийг ногоон байгууламж болгох	Төслийн нийт талбайн хэмжээнд	Зураглал	Дотоод зардал	Тухай бүр	-
Хөрсөн орчинд үзүүлэх нөлөөллийг тогтмол хянаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүрт төлөвлөн хэрэгжүүлж сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх	7	Хөрсөн орчны хяналт шинжилгээг тогтмол хийх	Төслийн нийт талбайн хэмжээнд	СДХ	ОХШТ-г тусгав	Жилд 1 удаа	MNS 5850:2019
	8	Газрын төлөв байдал, чанарын баталгааг хийлгэж, газар ашиглалтын тайлан мэдээг байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заасны дагуу гарган тайлагнах	Төслийн нийт талбайн хэмжээнд	Нэгж тайлан	2,000.0	2 жил тутамд	-
	9	Нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай бол арга хэмжээ авах	Агуулах, лабораторийн хэмжээнд	Нэгж тайлан	Дотоод зардал	Тухай бүр	MNS 5850:2019 MNS GOST 1510:2019
	10	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй химийн бодис, тос тосолгооны материалын хадгалалт, ашиглалтанд байнгын хяналт тавих	Төслийн нийт талбайн хэмжээнд	Нэгж тайлан	Дотоод зардал	Тухай бүр	MNS 5850:2019 MNS GOST 1510:2019
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотой үүсэх сөрөг нөлөөлөл	11	Агуулах орчмын ба дотоодын тээврийн замыг гэмдэгжүүлэх, анхааруулах самбар байрлуулах, талбайн зохион байгуулалтыг сайжруулах	Төслийн талбайн гадна орчинд	Нэгж тайлан	2,000.0	Тухай бүр	
	12	Тээврийн хэрэгслийг шатах тослох материалаар цэнэглэх засвар үйлчилгээ хийх талбайг тусгайлан засч тохижуулах	Төслийн талбайн гадна орчинд	Нэгж тайлан	2,000.0	Тухай бүр	
НИЙТ, мян. төгрөг					8,000.0		

5.3 Усан орчныг хамгаалах арга хэмжээ

Гол ба болзошгүй нөлөөлөл	№	Урьдчилан сэргийлэх болон бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Химийн бодис хүлээн авах, тээвэрлэх, хадгалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс	1	Химийн бодис, нэгдэл, шатах тослох материалын хадгалалт, ашиглалтанд байнгын хяналт тавих	Төслийн нийт талбайн хэмжээнд	Нэгж тайлан	Дотоод зардал	Тогтмол	MNS 5850:2019 MNS GOST 1510:2019
	2	Төслийн аль ч үе шатанд цэвэрлээгүй бохир усыг байгаль орчинд хаяхгүй байх арга хэмжээг зохион байгуулж ажиллах	Төслийн нийт талбайн хэмжээнд	Төлөвлөгөө, СДХ	Дотоод зардал	Тогтмол	MNS 4943:2015

Сүү, суун бүтээгдэхүүний үйлдвэрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023

химийн бодис алдагдаж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	3	Химийн бодис хадгалж байгаа болон ашиглаж буй газар үерийн хамгаалалт, даланг инженерчлэлийн нарийвчилсан үндэслэл тооцоотой хийх. Агуулах саванд тогтмол үзлэг хийж хянаж байх.	Төслийн нийт талбайн хэмжээнд	Нэгж тайлан	Дотоод зардал	Тогтмол	MNS 5850:2019
Усан орчинд үзүүлэх нөлөөлөл ямар байгааг хянаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүрт төлөвлөн хэрэгжүүлэх замаар сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.	4	Технологийн хэрэгцээнд ашигласан усны химийн найрлагын бүртгэл хяналт шинжилгээг тогтмол хийх	Төслийн нийт талбайн хэмжээнд	СДХ	ОХШХ-т тусгав	Тогтмол	MNS 4943:2015
